



**МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар A/357

Номгон

Г Иргэн О.Шаравын эзэмшил газрын
зөрчлийг арилгах тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн О.Шаравын (ВЖ67122215) Баянхонгор сум, Номгон 1-р баг, Худалдааны гудамжид байрлах 64009000596 нэгж талбарын дугаар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалттай 26.3 м² эзэмшил газрын илүү эзэмшиж буй 4.7 м² газрын үнийг төлүүлж зөрчлийг арилган, нэмж эзэмшүүлсүгэй.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн О.Шаравт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай



• 621010903